



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 11/36

Шивээговь сум

Үнэлгээ тогтоох комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд бүх төрлийн өмч хөрөнгө, эд материал мал амьтанд үнэлгээ хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Засаг даргын орлогч

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга

Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч

Багийн Засаг дарга нар

Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

Цагдаагийн хэсгийн дарга


Аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл

1, 2 дугаар багийн иргэн

2. Үнэлгээг орон нутгийн зах зээлийн ханшаар үнэн зөв, бодит байдлаар чанартай хийж гүйцэтгэн шийдвэрийг сумын Засаг даргад тухай бүр танилцуулахыг үнэлгээний комиссын даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421210240